



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/680

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Шархад овгийн Дамдинсүрэнгийн Түмэндэмбэрэл (РЛ74052000)-ийн Мөрөн сум 8 дугаар баг 9-45 тоотод байршилтай 6712018841 нэгж талбарын дугаартай 487м² гэр, орон сууцны хашааны газрын зориулалтаар эзэмшүүлсэн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул өөрийнх нь хүсэлтийн дагуу 40 жилийн хугацаагаар сунгаж эзэмшүүлсүгэй.
2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн №367 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 2 дахь заалтыг хүчингүй болгосугай.
3. Захирамжаар газар эзэмшигч иргэн Д.Түмэндэмбэрэлтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т нарт тус тус зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712012102